



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/17/НА-СТА-ОНӨ

Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт 2023 он	Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn Аудитор: Ө.Золзаяа Утас: 70512127 Цахим хаяг: zolzayau@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	7
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	8
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	9
4.1 Ерөнхий зүйл.....	9
4.2 Материаллаг байдал	9
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	9
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
4.5.1 Завсрын аудитын талаар	10
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
5.1 Төлбөрийн акт	10
5.2 Албан шаардлага	11
5.3 Зөвлөмж	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

БИЧИГТ ХӨГЖИЛ ОНӨААТҮГ-ИЙН
ЗАХИРАЛ Н.АРИУНТУНГАЛАГ ТАНАА

2023.03.22 № 160
танай - ны№ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бичигт хөгжил ОНӨААТҮГ нь тайлант оны өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хийж, тайланд илэрхийлсэн, цалин хөлс, түүнд ногдох татвар шимтгэлийг буруу тооцоолж олгосон, байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй зардал гаргаж хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, бараа материалын тайлан гаргаж баталгаажуулаагүй, шилэн дансны цахим системд бүртгүүлэн мэдээллийг ил тод байршуулж, мэдээлээгүй, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын систем хэрэгжихгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Бичигт хөгжил ОНӨААТҮГ нь аймгийн ИТХ-ын 2021 оны 08 сарын 59 тоот тогтоолоор үүсгэн байгуулагдсан. Тайлант хугацаанд шилэн дансны цахим системд шинээр бүртгэл үүсгэн, мэдээллийг байршуулж ажиллаагүй нь олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангаж ажиллаагүй бөгөөд үйл ажиллагааны ил тод, нээлттэй байх нөхцөл бүрдэхгүй байна.

Аудитын гол асуудал

Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ын дүрэмд эрхлэх үндсэн чиглэлийг тохижилт үйлчилгээ гэж тодорхойлсон боловч энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд аймаг орон нутгийн төсвөөс 74,350.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, Бичигт боомт дахь 7 айл өрхийн дулаан халаалтын төлбөр 8,100.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,194,607.00	26,201,063.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,501,607.00	11,597,163.68
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,501,607.00	11,597,163.68
3121	Төгрөг	1,501,607.00	11,597,163.68
31211	Төрийн сангийн харилцах	1,501,607.00	11,597,163.68
35	БАРАА МАТЕРИАЛ	7,693,000.00	14,603,900.00
354	Хангамжийн материал	7,693,000.00	14,603,900.00
35420	Аж ахуйн материал	7,693,000.00	9,979,900.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	4,624,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	4,916,666.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	00.00	4,916,666.66
392	Биет хөрөнгө	00.00	4,916,666.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	00.00	5,320,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-403,333.34
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,194,607.00	31,117,730.34
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,273,500.00	251,966.23
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,273,500.00	00.00
413	Өглөг	3,273,500.00	00.00
4136	Бусад өглөг	3,273,500.00	251,966.23
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,273,500.00	00.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	00.00	251,966.23
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,921,107.00	30,865,764.11
51	Засгийн газрын хувь оролцоо	5,921,107.00	30,865,764.11
512	Хуримтлагдсан үр дүн	5,921,107.00	30,865,764.11
51210	Өмнөх үеийн үр дүн	00.00	5,921,107.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	24,944,657.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,194,607.00	31,117,730.34

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	53,010,000.00	82,450,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,010,000.00	8,100,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,010,000.00	8,100,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,010,000.00	8,100,000.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	5,010,000.00	8,100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,000,000.00	74,350,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,000,000.00	74,350,000.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	48,000,000.00	74,350,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	40,541,868.00	57,505,342.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40,541,868.00	57,505,342.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,541,868.00	57,505,342.89
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,541,868.00	57,505,342.89
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	40,541,868.00	57,253,376.66
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	-	251,966.23
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	12,468,132.00	24,944,657.11
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	12,468,132.00	24,944,657.11

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	5,921,107.0	-	5,921,107.0
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	5,921,107.0	-	5,921,107.0
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	5,921,107.0	-	5,921,107.0
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	24,944,657.1	-	24,944,657.1
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	30,865,764.1	-	30,865,764.1

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	53,010,000.00	82,450,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,010,000.00	8,100,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,010,000.00	8,100,000.00
120009	Бусад орлого	5,010,000.00	8,100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,000,000.00	74,350,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,000,000.00	74,350,000.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	48,000,000.00	74,350,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	51,508,393.00	66,734,443.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,508,393.00	66,734,443.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,508,393.00	66,734,443.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,550,843.00	39,136,778.32
210101	Үндсэн цалин	11,750,843.00	39,136,778.32
210105	Гэрээт ажлын хөлс	1,800,000.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	1,993,665.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	1,393,665.00
210302	Түлш, халаалт	00.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,981,927.00	1,805,600.00
210401	Бичиг хэрэг	00.00	60,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,678,377.00	1,635,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	60,000.00	110,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	243,550.00	00.00
2105	Нормативт зардал	606,500.00	8,617,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	3,000,000.00
210502	Хоол, хүнс	00.00	3,460,240.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	606,500.00	2,156,960.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,157,123.00	15,037,600.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	777,000.00	4,220,000.00
210604	Урсгал засвар	27,380,123.00	10,817,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,012,000.00	143,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	100,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	12,000.00	43,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,200,000.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,200,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,501,607.00</u>	<u>15,715,556.68</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	5,320,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	5,320,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	5,320,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	5,320,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-5,320,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,501,607.00	10,395,556.68
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	1,501,607.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,501,607.00	11,597,163.68

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ийн зорилго нь хэрэглэгчдийг дулааны эх үүсвэрээр найдвартай, зохицуулалттай үнээр хангах, эрхлэх үйл ажиллагаанд тогтоосон нөхцөл, шаардлагыг чандлан биелүүлж ажиллах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд үйл ажиллагааны чиглэлийг тохижилт үйлчилгээ гэсэн төрлөөр тодорхойлсон байна.

3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээнд Бичигт хөгжил ОНӨААТҮГ хэлбэрээр 100 хувийн төрийн өмчлөлтэй, аймгийн Засаг даргад харьяалагдаж, үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бичигт хөгжил ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь өөрийн онцлогт тохирсон стандарт, хууль, тогтоол, дүрэм, журам, практик үйл ажиллагаанд үндэслэн батлуулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн бөгөөд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,923.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,501.6	11,597.2	10,095.6
Бараа материал	7,693.0	14,603.9	6,910.9
Үндсэн хөрөнгө	-	4,916.7	4,916.7
Нийт хөрөнгө	9,194.6	31,117.8	21,923.2
Өр төлбөр	3,273.5	252.0	(3,021.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,921.1	30,865.8	24,944.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,194.6	31,117.8	21,932.2

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 10,095.6 мянга, бараа материал 6,910.9 мянга, үндсэн хөрөнгө 4,916.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, өр төлбөр дансны үлдэгдэл 3,021.5 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Бичигт хөгжил ОНӨААТҮГ нь Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2021 оны 08 сарын 03-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор үүсгэн байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаа жигдэрч, тогтворжоогүйтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Бичигт хөгжил ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ө.Золзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2022 оны нийт зарлагын 82,450.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 824.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон гүйцэтгэлийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 /Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно/ дэх заалтын дагуу аймгийн ИТХ-аар ажилчдын жишиг цалин хөлсийг батлуулаагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 /нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх/ дахь заалтыг зөрчиж тус газрын үйл ажиллагаанд хамааралгүй үйл ажиллагаа болох ковидын 200 ш оношлуурыг 3,000.0 мянган төгрөгөөр худалдан авч нөөцөлж, хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 / хуулиар зөвшөөрөөгүй бусад/ дэх, 15 дугаар зүйлийн 15.1.7 /байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах/ дахь заалтыг зөрчиж хүлээн авалтын зардалд 1,811.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоон, албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовн дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ыг үүсгэн байгуулсан боловч шилэн дансны цахим системд бүртгүүлэн, мэдээллийг ил тод байршуулж, иргэдийг мэдээллээр хангах үүрэг хариуцлагаа биелүүлэхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Бичигт хөгжил ОНӨААТҮГ-т завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх жил санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй. (2021 оны 08 сард байгуулагдсан)

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,806.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 5,806.2 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, тус байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй үйл ажиллагаа болох ковидын оношлуур 3,000.0 мянган төгрөгөөр худалдан авч нөөцөлсөн, дулаан халаалтын төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, ажилчдын цалин хөлснөөс татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцолгүй бодож олгосон зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлж, үйл ажиллагаа, үр дүн, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх 3 зөвлөмж өглөө.

Мөн тайлант оны өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хийж, тайланд илэрхийлсэн, цалин хөлс, түүнд ногдох татвар шимтгэлийг буруу тооцоолж олгосон, байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй зардал гаргаж хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, бараа материалын тайлан гаргаж баталгаажуулаагүй, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын систем хэрэгжихгүй байгаа нь холбогдох хууль, журам, тушаал шийдвэрийг зөрчиж буй тул Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ын захирал, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулах албан тоотыг холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

- Аймгийн ИТХ-аар ажилчдын цалин хөлсний жишгийг тогтоож батлаагүй, ажилчидтай байгуулсан гэрээний мөнгөн дүн болон захирлын цалин тогтоосон тушаал шийдвэрээс өөр

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

дүнгээр цалин хөлсийг буруу тооцоолж, ажилчдад 3,995.2 мянган төгрөгийг илүү, дутуу цалин хөлс бодож олгосон.

- Тус байгууллагын дүрэм, үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй архи, согтуурах ундаа болон, хүлээн авалтад 1,811.0 мянган төгрөг зарцуулж хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.

5.2 Албан шаардлага

- Тус байгууллагын дүрэм, үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй үйл ажиллагаа болох 200 ширхэг ковидын оношлуур 3,000.0 мянган төгрөгөөр худалдан авч нөөцөлсөн байна.
- Дулаан халаалтын төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.
- Ажилчдын цалин хөлснөөс орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл тооцолгүй бодож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь /Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх /Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх /үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно/, 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх /хуулиар зөвшөөрөөгүй бусад/, 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь /нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх/, 15.1.7 дахь /байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах/, 15.2.6 дахь /байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох/ заалтыг тус тус зөрчсөн байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ хийж, иж бүрэн байх батламж мэдэгдлийг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн анхан шатны баримтаар иж бүрэн дэмжигдсэн ажил, гүйлгээг хийж, хүрэх үр дүн, гүйцэтгэлийг тооцож ажиллах

Илрүүлэлт 2: Ажлын цагийн бүртгэл, ажлын цагийн тооцоо, цалингийн тооцооны карт, цалин олгох хүснэгтийг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтын дагуу бүртгэн хөтөлж, баталгаажуулалгүй ажилчдын цалин хөлсийг бодож олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Ажлын цагийн бүртгэл, ажлын цагийн тооцоо, цалингийн тооцооны карт, цалин олгох хүснэгтийг батлагдсан маягтын дагуу үнэн зөв хөтлөн, захирлаар баталгаажуулж, цалин хөлс, нэмэгдлийн зардалд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах;

Илрүүлэлт 3: Бараа материалын бүртгэлийг аккурэл сууриар бүртгээгүй, СС-ын баталсан маягтаар бараа материалын тайланг эдийн засгийн ангилал бүрээр гаргаж, баталгаажуулаагүй нь ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл тодруулгын иж бүрэн байх, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын баталсан маягтын дагуу бараа материалын тайлан, орлого зарлагын гүйлгээг тухайн цаг хугацаанд хөтлөх, батламж мэдэгдлийн хүрээнд толилуулах

Илрүүлэлт 4: Шилэн дансны цахим системд бүртгүүлж, холбогдох мэдээллийг байршуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал тны тоо	Тоо	Дүн
Жишиг цалин хөлсийг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулаагүй, цалин хөлсийг буруу тооцоолж, ажилчдад илүү, дутуу цалин хөлс бодож олгосон	1	3,995.2	1	3,995.2	-	-	-	-	-	-	-	-
Байгууллагын дүрэм, үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй архи, согтуурах ундаа болон, хүлээн авалтын зардалд төсвийг үр ашиггүй зарцуулсан	1	1,811.0	1	1,811.0								
Үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй үйл ажиллагаа болох 200 ширхэг ковидын оношлуур худалдан авч нөөцөлсөн	1	3,000.0	-	-	1	3,000.0	-	-	-	-	-	-
Дулаан халаалтын төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
Ажилчдын цалин хөлснөөс, татвар, шимтгэл тооцолгүй бодож олгосон	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ хийж, иж бүрэн байх батламж мэдэгдлийг мөрдөж ажиллаагүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	
Ажлын цагийн бүртгэл, ажлын цагийн тооцоо, цалингийн тооцооны карт, цалин олгох хүснэгтийг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягын дагуу бүртгэн хөтөлж, баталгаажуулалгүй ажилчдын цалин хөлсийг бодож олгосон	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	
Бараа материалын бүртгэлийг аккурэл сууриар бүртгээгүй, СС-ын баталсан маягтаар бараа материалын тайланг эдийн засгийн ангилал бүрээр гаргаж, баталгаажуулаагүй нь ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл тодруулгын иж бүрэн байх, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	
Тайлант оны өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хийж, тайланд илэрхийлсэн, цалин хөлс, түүнд ногдох татвар шимтгэлийг буруу тооцоолж олгосон, байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй зардал гаргаж хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, бараа материалын тайлан гаргаж баталгаажуулаагүй, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын систем хэрэгжихгүй байгаа нь холбогдох хууль, журам, тушаал шийдвэрийг зөрчиж байна	2								2	-		

Дүн	10	8,806.2	2	5,806.2	3	3,000.0	3	-	2	-	-	-
-----	----	---------	---	---------	---	---------	---	---	---	---	---	---